



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 07

Мөрөн сум

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XVIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам батлах тухай" тогтоол нь утга найруулгын хувьд зөрчилтэй, одоо мөрдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтүүдтэй нийцэхгүй тул 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

2. Хүчингүй болсон тогтоолыг бүртгэлээс хасаж, орон нутгийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт мэдэгдэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төмөрхуяг)-д даалгасугай

ДАРГА  Т. МӨНГӨНХУЯГ

